



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/496

Булган сум

Цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Монголд Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103, Булган аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн их баяр наадмын Үндэсний сурын харваанд түрүүлсэн Архангай аймгийн Жаргалант сумын уугуул, сумын мэргэн Саранбилэг овогтой Баасандоржид “Аймгийн мэргэн” цол, хоёрдугаар байр эзэлсэн Говь-Алтай аймгийн Дарви сумын уугуул “Хангарьд” клубын тамирчин аймгийн гоц харваач, спортын мастер Пүрэвжавын овогтой Болд-Энх, Завхан аймгийн Алдар хаан сумын уугуул “Хилчин спорт” хорооны харваач аймгийн онч мэргэн спортын мастер Даваадоржын Энхжаргалд “Аймгийн гарамгай харваач” цол, гуравдугаар байр эзэлсэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын уугуул сумын мэргэн, спортын мастер Бямбадорж овогтой Наранцэцэгт “Аймгийн гоц харваач” цол, дөрөвдүгээр байр эзэлсэн Өмнөговь аймгийн Даланзадгад сумын уугуул “Ёл мэргэн” холбооны харваач спортын дэд мастер Намжилмаа овогтой Жавхланчимэгт “Аймгийн онч харваач” цол тус тус олгосугай.

2.Шинээр цол авсан харваачдад цолны үнэмлэх олгохыг баяр наадмын үндэсний сур харвааны салбар хороо /Д.Төгсбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Com.D.Tushaal2024

6324010703